



**ХЭНТИЙ АЙМАГ  
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 39

Бор-Өндөр

**ХЭЛНИЙ БОДЛОГЫН ОРОН ТООНЫ  
БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ ШИНЭЧЛЭН  
БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.17, Хэлний зөвлөлийн үндэсний зөвлөлийн 2016 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арванхоёрдугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа, бодлого чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Бор-Өндөр суманд "Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөл"-ийг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Монгол хэлний тухай хууль, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө, "Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэн, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд салбар зөвлөлийн дарга (П.Чинбат)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороон дарга (Ж.Энх-Оргил)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 36 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Д.ОТГОНЦЭЦЭГ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 12 дугаар сарын 19 ний өдрийн  
39 дүгээр тогтоолын хавсралт



Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

Хэлний бодлогын орон тооны бус зөвлөлийн дарга: Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Монгол хэл, уран зохиолын мэргэжлийн хөгжлийн бүлгийн  
ахлагч

Гишүүд:

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга
- Нийгмийн бодлогын мэргэжилтэн
- Бор-Өндөр цогцолбор сургуулийн Захирал
- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн Захирал
- Насан туршийн боловсролын багш
- Соёлын төвийн Эрхлэгч
- Их ирээдүй сургуулийн Захирал
- 3 дугаар цэцэрлэгийн Эрхлэгч